

**НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН
ХОРООНЫ ДАРГА ТУШААЛ**

2018 оны 06 сарын 08 өдөр

Д. /30


Улаанбаатар хот

Г Хийн болон аэробик дасгалын сургагч
багш бэлтгэх сургалт, семинарыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Засгийн газрын 2009 оны 05 дугаар тогтоол, 2017 оны 289 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


1. Хийн болон аэробик дасгалын сургагч багш бэлтгэх сургалт, семинарыг 2018 оны 06 дугаар сарын 11-22-ны өдрүүдэд Үндэсний Биеийн тамирын дээд сургуулийн зааланд зохион байгуулсугай.
2. Сургалт семинарт зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, хичээл заах багш нарын бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 3.150.000 /Гурван сая нэг зуун тавин мянган/ төгрөгийг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны уралдаан тэмцээний сургалт семинарийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /О.Эрдэнэцэцэг/-д зөвшөөрсүгэй.
4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтэс /А.Болдмаа /- т үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хорооны
даргын 2018 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн
11.30 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Хийн болон аэробик дасгалын сургагч
бэлтгэх сургалт семинарийн төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн /төг/
1.	Багийн ажлын зардал: 10 хоног х 60 цаг 30.000 төг = 1.800.000 төг	1.800.000
2.	Заал талбайн зардал	600.000
3.	Гарын авлага, сурталчилгаа	600.000
4.	Сертификат хэвлүүлэх	100.000
5.	Видео бичлэг, анонс	50.000
Нийт дүн		3.150.000